



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Цахир сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/137/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn
Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Гэрээгээр аудит гүйцэтгэсэн:
Бизкон аудит ХХК Архангай аймаг дахь салбар
Ахлах аудитор Ч.Анхбаяр
Утас: 8511-6555
Цахим хаяг: ankha964@gmail.com

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
5.1 Төлбөрийн акт.....	11
5.2 Зөвлөмж.....	11
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БГАҮТХ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.25 № 121

танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦАХИР
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.ХҮЧНЭМЭХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Цахир сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Эмнэлгийн тусламж үйлчилгээ” хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 804,208.2 мянган төгрөг, 52,971.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 12,047.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 63,605.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, нийт 932,832.0 мянган төгрөгийг бүрдүүлж, төсвийн зардлын нийт гүйцэтгэлээр 925,055.9 мянган төгрөг буюу 93.61 хувьтай зарцуулж, төрийн сангийн дансанд 7,776.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 үндсэн зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, арга хэмжээний хэрэгжилтийг Цахир сумын Засаг дарга 92.5 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	181,522,557.98	267,261,281.88
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	12,047,061.50	7,776,202.17
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	12,047,061.50	7,776,202.17
3121	Төгрөг	12,047,061.50	7,776,202.17
31211	Төрийн сангийн харилцах	12,047,061.50	7,776,202.17
33	АВЛАГА	14,956,293.00	105,296,811.66
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	14,956,293.00	105,296,811.66
35	БАРАА МАТЕРИАЛ	154,519,203.48	154,188,268.05
351	Түүхий эд материал	99,611,227.98	100,100,885.55
35110	Тусгай зориулалттай материал	56,660,533.85	61,423,098.25
35130	Эм боох материал	42,950,694.13	38,677,787.30
354	Хангамжийн материал	54,907,975.50	54,087,382.50
35410	Бичиг хэргийн материал	576,300.00	447,300.00
35420	Аж ахуйн материал	40,985,872.50	32,745,162.50
35440	Түлш, шатах тослох материал	12,850,000.00	20,740,000.00
35460	Хүнсний материал	495,803.00	154,920.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	335,477,705.65	2,398,086,931.23
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	335,477,705.65	2,398,086,931.23
392	Биет хөрөнгө	317,059,705.65	2,379,668,931.23
39201	Барилга, байгууламж, орон сууц	268,794,747.18	2,219,410,893.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	-87,714,913.63	-98,652,978.75
39203	Авто-тээврийн хэрэгсэл	115,679,556.00	124,229,556.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-33,986,823.51	-51,813,234.71
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	151,092,656.15	263,509,161.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	-96,767,644.24	-109,055,343.26
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,467,058.00	41,717,058.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,504,930.30	-9,676,180.38
393	Биет бус хөрөнгө	18,418,000.00	18,418,000.00
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	17,368,000.00	17,368,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	517,000,263.63	2,665,348,213.11
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	5,389,790.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	5,389,790.00
413	Өглөг	-	5,389,790.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	4,189,790.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	517,000,263.63	2,659,958,423.11
51	Засгийн газрын хувь оролцоо	517,000,263.63	2,659,958,423.11
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	238,315,520.04	238,315,520.04
51101	Өмч: - төрийн	238,315,520.04	238,315,520.04
512	Хуримтлагдсан үр дүн	160,783,894.79	2,303,742,054.27
51210	Өмнөх үеийн үр дүн	160,783,894.79	160,783,894.79
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,142,958,159.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	117,900,848.80	117,900,848.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	517,000,263.63	2,665,348,213.11

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	743,559,444.71	3,093,565,403.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	122,103,405.58	2,136,094,656.79
120	Нийтлэг татварын бус орлого	122,103,405.58	2,136,094,656.79
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		63,605,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		105,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		63,500,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө	82,720,300.00	2,045,255,846.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	39,383,105.58	27,233,810.79
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	621,456,039.13	957,470,746.28
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,836,120.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,836,120.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41,975,000.00	62,922,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,975,000.00	62,922,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	558,644,919.13	894,548,746.28
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	558,644,919.13	894,548,746.28
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	664,392,403.23	950,607,243.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	664,392,403.23	950,607,243.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	649,118,391.55	940,657,116.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	407,494,798.02	621,274,781.15
210101	Үндсэн цалин	279,608,560.45	360,715,301.19
210102	Нэмэгдэл	98,909,042.79	193,162,903.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	4,118,000.00
210104	Урамшуулал	16,191,338.24	63,278,576.77
210105	Гэрээт ажлын хөлс	12,785,856.54	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,160,564.90	85,025,200.00
210201	Тэтгэврийн даатгал	37,875,473.05	63,514,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,321,610.85	5,377,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,456,283.47	2,688,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	864,272.84	2,688,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,642,924.69	10,755,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,280,788.32	40,644,373.00
210301	Гэрэл, цахилгаан	2,905,738.32	9,932,373.00
210302	Түлш, халаалт	14,825,050.00	30,712,000.00
210303	Цэвэр, бохир ус	550,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	48,461,660.00	43,306,610.00
210401	Бичиг хэрэг	3,753,800.00	3,748,600.00
210402	Тээвэр, шатахуун	27,233,160.00	30,708,910.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	829,500.00	1,526,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,525,200.00	7,083,100.00
2105	Нормативт зардал	85,665,274.52	82,173,467.02

Архангай аймгийн Цахир сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,228,663.52	68,668,424.02
210502	Хоол, хүнс	10,436,611.00	8,538,043.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	4,967,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,009,000.00	10,303,460.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,991,960.00
210604	Урсгал засвар	1,009,000.00	6,311,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,714,000.00	14,000,000.00
210702	Дотоод албан томилолт	2,714,000.00	14,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	529,500.00	1,800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	1,700,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,802,805.79	42,129,225.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	710,000.00	905,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,092,805.79	41,223,425.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,274,011.68	9,950,127.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,274,011.68	9,950,127.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,274,011.68	9,950,127.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>79,167,041.48</u>	<u>2,142,958,159.48</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	323,584.48	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	323,584.48	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-323,584.48	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>78,843,457.00</u>	<u>2,142,958,159.48</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>606,499,746.13</u>	<u>930,735,227.62</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	<u>63,605,000.00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	-	63,605,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	63,605,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		105,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	63,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>606,499,746.13</u>	<u>867,130,227.62</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,836,120.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,836,120.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41,975,000.00	62,922,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,975,000.00	62,922,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	543,688,626.13	804,208,227.62
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	543,688,626.13	804,208,227.62
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>619,637,323.92</u>	<u>876,429,281.95</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>619,637,323.92</u>	<u>876,429,281.95</u>

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	604,363,312.24	866,479,154.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	407,494,798.02	621,274,781.15
210101	Үндсэн цалин	279,608,560.45	360,715,301.19
210102	Нэмэгдэл	98,909,042.79	193,162,903.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	4,118,000.00
210104	Урамшуулал	16,191,338.24	63,278,576.77
210105	Гэрээт ажлын хөлс	12,785,856.54	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,160,564.90	85,025,200.00
210201	Тэтгэврийн даатгал	37,875,473.05	63,514,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,321,610.85	5,377,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,456,283.47	2,688,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	864,272.84	2,688,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,642,924.69	10,755,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,182,788.32	48,534,373.00
210301	Гэрэл, цахилгаан	2,905,738.32	9,932,373.00
210302	Түлш, халаалт	20,727,050.00	38,602,000.00
210303	Цэвэр, бохир ус	550,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	35,750,310.00	41,005,610.00
210401	Бичиг хэрэг	3,402,200.00	3,117,400.00
210402	Тээвэр, шатахуун	26,433,160.00	30,100,910.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	829,500.00	1,526,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	680,200.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,405,250.00	6,021,300.00
2105	Нормативт зардал	58,804,541.00	48,845,690.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	43,904,851.00	38,463,530.80
210502	Хоол, хүнс	9,701,690.00	8,197,160.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,198,000.00	2,185,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,212,010.00	5,905,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,550,010.00	1,468,000.00
210604	Урсгал засвар	4,662,000.00	4,437,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,714,000.00	14,000,000.00
210702	Дотоод албан томилолт	2,714,000.00	14,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	529,500.00	600,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,514,800.00	1,288,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,514,800.00	1,288,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,274,011.68	9,950,127.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,274,011.68	9,950,127.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,274,011.68	9,950,127.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(13,137,577.79)	54,305,945.67
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	58,576,805.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	58,576,805.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	58,576,805.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	58,576,805.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-58,576,805.00

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(13,137,577.79)	-4,270,859.33
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		12,047,061.50
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,047,061.50	7,776,202.17

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	238,315,520.04	117,900,848.80	160,783,894.79	517,000,263.63
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	238,315,520.04	117,900,848.80	160,783,894.79	517,000,263.63
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	238,315,520.04	117,900,848.80	160,783,894.79	517,000,263.63
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	2,142,958,159.48	2,142,958,159.48
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	238,315,520.04	117,900,848.80	2,303,742,054.27	2,659,958,423.11

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	988,216,500.00	925,055,959.95	63,160,540.05	93.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	988,216,500.00	925,055,959.95	63,160,540.05	93.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	988,216,500.00	925,055,959.95	63,160,540.05	93.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	665,668,400.00	621,274,781.15	44,393,618.85	93.33
210101	Үндсэн цалин	366,717,000.00	360,715,301.19	6,001,698.81	98.36
210102	Нэмэгдэл	229,073,700.00	193,162,903.19	35,910,796.81	84.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,346,000.00	4,118,000.00	1,228,000.00	77.03
210104	Урамшуулал	64,531,700.00	63,278,576.77	1,253,123.23	98.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,025,200.00	85,025,200.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	62,869,700.00	63,514,700.00	-645,000.00	101.03
210202	Тэтгэмжийн даатгал	5,700,100.00	5,377,600.00	322,500.00	94.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,688,800.00	2,688,800.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,688,800.00	2,688,800.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,077,800.00	10,755,300.00	322,500.00	97.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,922,000.00	48,534,373.00	9,387,627.00	83.79
210301	Гэрэл, цахилгаан	18,000,000.00	9,932,373.00	8,067,627.00	55.18

Архангай аймгийн Цахир сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	38,602,000.00	38,602,000.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	1,320,000.00	-	1,320,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,701,100.00	41,005,610.00	1,695,490.00	96.03
210401	Бичиг хэрэг	3,308,800.00	3,117,400.00	191,400.00	94.22
210402	Тээвэр, шатахуун	30,500,000.00	30,100,910.00	399,090.00	98.69
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,861,200.00	1,526,000.00	335,200.00	81.99
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	431,100.00	240,000.00	191,100.00	55.67
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,600,000.00	6,021,300.00	578,700.00	91.23
2105	Норматив зардал	54,966,900.00	48,845,690.80	6,121,209.20	88.86
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	43,342,900.00	38,463,530.80	4,879,369.20	88.74
210502	Хоол, хүнс	9,374,000.00	8,197,160.00	1,176,840.00	87.45
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,250,000.00	2,185,000.00	65,000.00	97.11
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	65,287,000.00	64,482,305.00	804,695.00	98.77
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,287,000.00	30,044,805.00	242,195.00	99.20
210602	Тавилга	30,000,000.00	30,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,437,500.00	562,500.00	88.75
2107	Томилолт, зочны зардал	14,062,000.00	14,000,000.00	62,000.00	99.56
210702	Дотоод албан томилолт	14,062,000.00	14,000,000.00	62,000.00	99.56
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	600,000.00	600,000.00	-	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	100,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,983,900.00	1,288,000.00	695,900.00	64.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,983,900.00	1,288,000.00	695,900.00	64.92
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	988,216,500.00	920,785,100.62	67,431,399.38	93.17
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	62,922,000.00	52,971,873.00	9,950,127.00	84.19
132001	Орон нутгийн төсвөөс	62,922,000.00	52,971,873.00	9,950,127.00	84.19
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	849,747,500.00	804,208,227.62	45,539,272.38	94.64
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	849,747,500.00	804,208,227.62	45,539,272.38	94.64
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	75,547,000.00	63,605,000.00	11,942,000.00	84.05
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	63,500,000.00	63,500,000.00	-	100.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	12,047,000.00	-	12,047,000.00	0.00

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		12,047,061.50	(12,047,061.50)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		7,776,202.17	(7,776,202.17)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27	27	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	10	10	0.00	100.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй

Аудитаар нийт 59,379.4 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд төсөвт төвлөрүүлэх 1 төлбөрийн акт, зөрчлийг таслан зогсоох 59,379.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь 34,502.6 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 6,917.5 мянган төгрөгөөс материаллаг алдаа зөрчил нь их байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Авто машины шатахууны зардалд шаардах хуудас, жолоочийн тооцооны хуудас зэрэг анхан шатны баримтгүй 802.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", 13.6. "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн, Зам тээврийн хөгжлийн Сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

5.2.1 Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 97 нэр төрлийн 160 ширхэг 69,915.4 мянган төгрөгийн хөрөнгөнд холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох байх албан шаардлага хүргүүллээ

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Тайлант онд 58,576.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд гэрээгээр худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.1.Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан аргаар зохион байгуулна., 34 дүгээр зүйлийн 34.1-д "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно."48.2.1.худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах; Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын 2-д "Энэ тогтоолын хавсралтаар тогтоосон төсөвт өртгийн дээд хязгаарыг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалагч нарт, ... даалгасугай" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгссөн зөвлөмж: Бараа, материал, үндсэн хөрөнгө худалдан авахаар хэлэлцэж шийдвэрлэсний дараа Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг мөрдөж худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулах арга хэмжээг авч биелэлтийг хангаж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 03 дугаарын 22-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлаг а тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шатахуун нотлох баримтгүй зарцуулсан	1	802.6	1	802.6								
Шүүд гэрээгээр худалдан авалт хийсэн	1	58,576.8					1	58,576.8				
Үлдэх өртөггүй хөрөнгийг хугацааг сунгаж үнэлэх	1	0			1	0						
Дүн	3	59,379.4	1	802.6	1	0	1	58,576.8				